



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/299

Булган сум

“Сансар марафон-2026” гүйлтийн тэмцээнийг
зохион байгуулах ажлын хэсгийг томилж,
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хүн сансарт ниссэний 45 жилийн ой, Булганчуудын бахархлын өдрийг тохиолдуулан гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Сансар марафон-2026” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)

Гишүүд:

Э.Эрболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, хурандаа)

Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)

В.Батболд (Аймгийн Хөнгөн атлетикийн холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын тамгын газрын

6326010407

Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах 15,671,000 (арван таван сая зургаан зуун далан нэгэн мянга) төгрөгийн төсвийг хавсралтаар баталж, хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 21-ний өдрийн
А/299 дугаар захирамжийн хавсралт

“Сансар марафон 2026” арга хэмжээний төсөв

Д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Мөнгөн шагнал	176	70,455	12,400,000
2	Медаль	108	9500	1,026,000
3	Өргөмжлөл, цоолтууртай цаасан	176	2000	352,000
4	Талархлын өргөмжлөл цоолтууртай цаасан	25	2000	50,000
5	Талархлын өргөмжлөл-модон	25	35,000	875,000
6	Мөнгөний дугтуй	176	500	88,000
7	Батламж оролцсон нийт тамирчдад	880	1000	880,000
НИЙТ ДҮН				15,671,000

--o00o--